# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр　　　　Дугаар А/322　　　　Номгон

Иргэн Д.Ганбатын эзэмшил газрын
зөрчлийг арилгах тухай

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай" 135 дугаар тогтоолын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Д.Ганбатын (ВП69122819) худалдаа, үйлчилгээний зориулалттай 82 м2 эзэмшил газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул зөрчлийг арилган илүү эзэмшиж буй 4 м2 газрын үнийг төлүүлэн нэмж эзэмшүүлж хавсралтаар баталсугай.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Д.Ганбатад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА　　　　Д.МӨНХСАЙХАН

621010821

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
А322 дугаар захирамжийн хавсралт

# ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

| д/д | Газар эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Зориулалт | Хаяг | Талбайн хэмжээ /м2/ | Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/ | Нийт талбайн хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Д.Ганбат | ВП69122819 | 040700265 | Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | Баянхонгор сум, Номгон 1-р баг, Худалдааны гудамж-, тоот | 82 м2 | 4 м2 | 86 м2 |

_____oOo_____

0320110032
0007242 ГСТ7121